



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 0/104

Улаанбаатар хот


**Хөрөнгө хүлээн авах ажлын  
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/527 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ-т “Улаанбаатар зам засвар арчлалтын газрын машин, механизм нийлүүлэх” тендер /УБ33АГ/ММН-2019/-ийн гэрээт ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан “Монгол ташуур констракшн” ХХК-аас нийлүүлэх хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.


2. “Монгол ташуур констракшн” ХХК-тай байгуулсан гэрээгээр “Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ-т нийлүүлэгдэж буй авто ачигч машиныг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 03. дугаар сарын 25. өдрийн 0/102. тоот тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: С.Ариунжаргал Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга

Гишүүд:

Т.Оюунсүвд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс

Б.Баатархүү Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер

Д.Ариунболд Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын Үйл ажиллагааны төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

М.Энхболд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн